ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 дугаар сарын 25 Улаанбаатар хот

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ. ‘’КОВИД-19’’ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилго 1.1 "Ковид-19" цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 1 | 1.1.2.1.Нийслэлийн Гамшгаас хамгаалах албадад “Шуурхай штаб” байгуулж, тохиолдлын голомтод үүрэг гүйцэтгэх шуурхай арга хэмжээний багийн бэлэн байдлыг хانган ажиллана. | Тоо | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Нийслэлийн Онцгой байдлын газар | Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Нийслэлийн Онцгой комиссын дэргэд Шуурхай штаб байгуулан ажиллаж байна. | - | Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хугацаа дууссан. /2022 онд хэрэгжиж дууссан/ | 100 |
| 2 | 1.1.2.4.“Ковид-19” цар тахлын голомт, ойрын болон дам хавьтагчдыг илрүүлж тухайн бүсэд | Тоо | Нийслэлийн Эрүүл мэндийн газар | Нийслэлийн хэмжээнд 410 тохиолдлыг илрүүлэн, | - | Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хязгаарлалт тогтоон тархалтыг зогсоох арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | Нийслэлийн Онцгой байдлын газар | хяналтад авсан. /2020 оны 12 сарын 31-ний байдлаар/ | | бууруулах тухай хуулийн хугацаа дууссан. /2022 онд хэрэгжиж дууссан/ | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилго 2.2. Иргэдийг бие тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана.** | | | | | | | |
| 3 | 2.2.1.3. Иргэдэд үзүүлэх бие тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулна. | Тоо | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар | Магадлан итгэмжлэгдсэн 11 спорт клуб ажиллаж байна. | Магадлан итгэмжлэгдсэн 6 спорт клуб шинээр нэмэгдүүлсэн байна. | Дүүргийн хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн 4 спортын клуб үйл ажиллагаа явуулдаг ба иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хорооноос улирал тутамд тогтмол хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 4 | 2.2.1.4.Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /Улаанбаатар Марафон, Иргэдийн Спортын наадам, Төрийн албан хаагчдын наадам гэх мэт/ | Тоо | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар | Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 315196 хүн оролцсон. | Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчдын тоог 35000 хүнээр нэмэгдүүлж 450196-д хүргэсэн байна. | Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд нийт 31 удаагийн тэмцээн уралдаан болон олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 482 байгууллагын 18201 тамирчид хамрагдсан.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд биеийн тамир, спортын нээлттэй өдөрлөгийг спортын 3 төрлөөр зохион байгуулж 6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын 90 иргэн хамрагдсан.<br>-Дүүргийн ахмадуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл хэв маягийг хэвшүүлэх зорилгоор спортын 4 төрлөөр арга хэмжээг зохион байгуулж 89 байгууллагын 1100 иргэн хамрагдсан.<br>-Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын багш, ажилтан, албан хаагчдын дунд “Спорт наадам-2024” арга хэмжээг спортын 6 төрлөөр зохион байгуулж 111 байгууллагын 800 ажилтан, албан хаагчид хамрагдан оролцсон.<br>-Дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилтан, албан хаагчдын дунд спортын 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулж 36 байгууллагын 792 ажилтан, албан хаагчид хамрагдсан.<br>-Залуучууд болон ахмадын самбо бөхийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын самбо бөхийн холбоотой хамтран зохион байгуулж 50 байгууллагын 350 тамирчин хамрагдсан.<br>-Дүүргийн Идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг сагсан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бөмбөг, дартс, ширээний теннисийн төрлүүдээр Залуучууд хөгжлийн зөвлөлтэй хамтран зохион байгуулж, 24 байгууллагын 288 тамирчид хамрагдсан.<br>-“Эртэч Чингэлтэйчүүд” аяныг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас хамтран зохион байгуулж 31 байгууллагын 2685 иргэд, ажилтан, албан хаагчид хамрагдсан.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газраас “ЗӨВ ЗАЛУУС” уриан дор зохион байгуулагдсан “ЧИНГЭЛТЭЙН ЦОМ-2024” 9 төрөлт спортын их наадмыг зохион байгуулж 24 байгууллагын 1500 тамирчид хамрагдсан.<br>-"Улаанбаатар марафон" Олон Улсын тэмцээнд 82 байгууллагын 4600, “Илүүдэл жингээ хасъя” аяныг зохион байгуулж 24 байгууллагын 132, дүүргийн Засаг даргын нэрэмжит “Иргэдийн спортын XII” их наадмыг спортын 9 төрөлт тэмцээнийг нийт 117 байгууллагын 1706 иргэдийн дунд тус тус зохион байгуулан ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 2.2.1.5.Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Тоо | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар | Өвлийн улиралд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд 410000 хүн оролцсон байна. | Өвлийн улиралд биеийн тамираар хичээллэгч, арга хэмжээнд оролцогчдын тоог 1000 хүнээр нэмэгдүүлж 414000-д хүргэсээн байна. | Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэхээр дүүргийн Засаг даргын дэргэдэх тэшүүрийн Өсвөрийн шигшээ багийн нийт 50 тамирчин, 2 дасгалжуулагч тогтмол бэлтгэл сургуулилтаа хийж байна. “Хоккейн аварга” шалгаруулах тэмцээнийг 3 удаа зохион байгуулж 38 байгууллагын 750 тамирчин хамрагдсан. Дүүргийн Биеийн тамир, спортын хорооны хоккейн талбайд иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор чөлөөт гулгалтуудыг зохион байгуулж 5700 иргэнд үйлчилсэн ба дүүргийн Тусгаар тогтнолын талбайд мөсөн гулгуурыг бий болгон иргэдэд үйлчилгээг тус тус үзүүлж байна. Тэшүүрийн спортыг хөгжүүлэх зорилгоор 2 удаагийн үнэ төлбөргүй сургалт зохион байгуулснаар 120 хүүхдийг хамруулсан. | 100 |
| 6 | 2.2.2.1.Багийн спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ. | Тоо | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар | 145,000 хүүхэд багачуудыг спортын үйл ажиллагаанд хамруулсан. | Багийн спортын төрлөөр зохион байгуулсан тэмцээн, уралдаанд оролцогчдын | -Дүүргийн Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 11 төрлөөр зохион байгуулж давхардсан тоогоор 176 байгууллагын 3056 тамирчин хамрагдсан.<br>-Дүүргийн “Сурагчдын хөгжөөн дэмжигчид”-ийн аварга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоог 50 хүнээр нэмэгдүүлж 145250-д хүргэсэн байна. | шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 7 байгууллагын 120 сурагчид хамрагдсан.<br>-Дүүргийн цэцэрлэгийн хүүхдүүдийн “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 10 байгууллагын 300 хүүхэд хамрагдсан.<br>-“Хоккейн” өсвөрийн шигшээ багийн тамирчид 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс 02 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Хөх хот”-д зохион байгуулагдсан “U14” насны тэмцээнд оролцож, алтан медаль, “Жүдо бөх”-ийн өсвөрийн шигшээ баг нь 2024 оны 04 дүгээр сард Казакстан Улсын Актая хотод зохион байгуулагдсан тэмцээнд оролцож 58 кг-ийн жинд Э.Наранзун хүрэл медалийн амжилтыг тус тус үзүүлсэн байна. | |
| 7 | 2.2.2.2.Биеийн тамир, спортын төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэлд тулгуурлан спортын уралдаан тэмцээнүүдийн чанар зохион байгуулалтыг сайжруулна. | Тоо | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар | Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд 7,096 иргэнийг хамруулсан. | Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцогч тамирчдын тоог 40 тамирчнаар | Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнээс спортын гимнастикийн төрлөөр 19 алтан медаль, 19 мөнгөн медаль, 10 хүрэл медаль, шатрын төрлөөр 1 алтан медаль, 2 хүрэл медаль, Таеквондо төрлөөр 7 алтан медаль, 4 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэгдүүлж 7,250-д хүргэсэн байна. | мөнгөн медаль, 5 хүрэл медаль, Ширээний теннисийн төрлөөр 2 алтан медаль, 4 мөнгөн медаль, 3 хүрэл медалиар тус тус шагнагдлаа. Иргэдийн спортын XII их наадмын “Явган аялал”-ын шигшээ тэмцээнд 13 дугаар хорооны 12 иргэн амжилттай оролцож дөрөвдүгээр байрт шалгарсан. | |
| 8 | 2.2.2.5. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлнэ. | Тоо | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар | Дүүргийн Засаг даргын дэргэд спортын 22 төрлөөр шигшээ баг хичээллүүлж байна. | Өсвөрийн шигшээ багуудын спортын төрлийн тоог нэгээр нэмэгдүүлж, 25-д хүргэсэн байна. | Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024 оны А/17 дугаар захирамжийн хүрээнд 2024 онд жүдо бөх, таеквондо, чөлөөт бөх, хөнгөн атлетик, волейбол, сагсан бөмбөг, усан спорт, хоккей, үндэсний бөх, шатар, спортын гимнастик, ширээний теннис, тэшүүр, хөл бөмбөг, бокс зэрэг 15 төрлөөр өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчидтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. 2024 онд өсвөрийн шигшээ багийн тамирчид Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 хүрэл медаль, Олон улс болон улсын чанартай 56 удаагийн тэмцээнд оролцож 395 медаль, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 65 алтан медаль, 49 мөнгөн медаль, 70 хүрэл медаль, Хотын аварга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгаруулах тэмцээнээс 29 алтан медаль, 27 мөнгөн медаль, 20 хүрэл медаль, Нэрэмжит тэмцээнээс 42 алтан медаль, 27 мөнгөн медаль, 44 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | |
| 9 | 2.2.3.4.Биеийн тамир, спортын хуучин талбайнуудыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй зөвшилцөн эргүүлэн авах, уг талбайнуудыг нийтийн эдэлбэр газраар үлдээж, сэргээн засна. | Тоо | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба | - | - | Дүүргийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж буй биеийн тамир, спортын хуучин газар, талбай байхгүй болно. | 100 |
| **БОЛОВСРОЛ** | | | | | | | |
| **2.3.Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлсэн, суралцагчийн хөгжлийг дэмжсэн “Нийслэлийн боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 10 | 2.3.1.1.Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна. | Хувь | Нийслэлийн Боловсролын газар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Нийт багшийн 12 хувийг мэргэшүүлэх болон давтан сургалтад хамруулж байна. | Мэргэшүүлэх болон давтан сургалтад хамрагдсан багшийн эзлэх хувийг 26 хувьд хүргэсэн байна. | Боловсрол, Шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үнэлгээ хариуцсан ажилтны чиг үүрэг, багш, суралцагч, сургалтын байгууллагын үнэлгээний талаар мэдээлэл арга аргачлалд сургах зорилгоор төрийн өмчийн цэцэрлэгийн 38 эрхлэгчийг сургалтад хамруулсан. Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Сургалтын менежментийн цикл” сэдэвт цахим сургалтад төрийн өмчийн цэцэрлэгийн 100 багшийг хамруулсан. Дүүргийн биеийн тамирын багш нарын туршлага солилцох сургалт, "Нийслэлийн МХБ-ийн багийн үйл ажиллагаа" сэдвээр сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, дүүргийн багшийн мэргэжлийн бүлгийн нийт 23 гишүүн оролцсон. Түүх нийгмийн ухааны багш нарын зөвлөгөөн "Чингис хаан" музейд зохион байгуулагдаж, 30 багш хамрагдсан.<br>ЕБС болон СӨБ-ын багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн 1, 5, 10, 15 жилийн сургалтад Ерөнхий боловсролын сургууль болон Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нийт 354 багш хамрагдсан. Цэцэрлэгийн ОУ-ын Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цэцэрлэгийн багш нарыг чадавхжуулах сургалтад 31 цэцэрлэгийн 148 багшийг хамруулсан. Багануур дүүргийн Монгол хэл бичгийн багш нарын Сургалтын орчны стандартыг хэрэгжүүлэх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох үзүүлэх ажилд 5 арга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зүйч оролцсон. Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээнд 4 цэцэрлэгийн 8 арга зүйч хамрагдсан. Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн гишүүдийн сургалт зөвлөгөөнд 10 эрхлэгч, арга зүйч, дунд, ахлах ангийн сургалтын менежерүүдийн цахим сургалтад 32 менежер хамрагдсан. Pearson англи хэлний цогц хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалтад зорилтот 14 багш, хөгжмийн багш нарын графикт сургалтад 18 багш, МХУЗ-ын судлагдахууны ахлагч нарын графикт сургалтад 16 багш, нийгмийн ажилтнуудын графикт сургалтад 20, дүүргийн боловсролын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд 170 хүн тус тус оролцсон. Эдүтэн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Бага боловсролын 15 сургалтын менежерт график сургалт зохион байгуулсан. | |
| 11 | 2.3.1.2.Багш ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэх, сурлагын амжилт, чанарыг ахиулах зорилгоор индексийн урамшуулал олгох | Хувь | Нийслэлийн Боловсролын газар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Нийслэлийн тэргүүний сургууль, цэцэрлэгийн болзол хангаж урамшуулал | Багшийг ажлын байрандаа хөгжих нөхцөл, боломжийг бүрдүүлсэн, сургалтын | 1.Бага боловсролын багш нарын ажлын байрандаа хөгжихөд зориулан "Бид алдаагүй зөв бичигтэн" аяныг зохион байгуулж, нийт 17 сургуулийн 346 багш оролцсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | уралдаант шалгаруулалтыг зохион байгуулна. | | | авсан 132 байгууллага байна. | амжилт чанарыг ахиулсан байгууллагын тоог 35-иар нэмэгдүүлсэн байна. | 2.Багш ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэх, сурлагын амжилт, чанарыг ахиулах зорилгоор Улсын хэмжээнд зохион байгуулсан индексийн урамшуулал олгох гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд явагдаж, дүүргийн хэмжээнд нийт 900 багш хамрагдсан. Боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний 6 шалгуурыг бүрэн хангаж индексийн түвшингээ ахиулсан дүүргийн 155 дугаар цэцэрлэг 3 сая төгрөгийн урамшууллыг авсан.<br>3.Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээл сургалтын зардлаас санхүүжүүлж, багш хөгжүүлэх чиглэлээр давхардсан тоогоор 115 сургалтыг нийт 968 багшид зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээгээр I-0, II-4, III-5, IY-2, Y-9 байгууллага үнэлэгдэж, 2 байгууллага индексийн шалгуурт орох боломжтой болсон. | |
| 12 | 2.3.1.3.Боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, дэмжин ажиллаж, багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх механизм бий болгон хэрэгжүүлнэ. | Тоо | Нийслэлийн Боловсролын газар | Ерөнхий боловсролын сургуулиудын гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын баталгаажуулсан хөтөлбөрийн тоо 450 байна. | Ерөнхий боловсролын сургуулиудын гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын баталгаажсан хөтөлбөрийн тоог 800-д хүргэсэн байна. | 1.Дүүргийн хэмжээнд гүнзгийрүүлсэн сургалтаар гадаад хэл, математик, хими, биеийн тамирын хичээлийн нийт 109 хөтөлбөрийг баталгаажуулан сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулж байна.<br>2.Багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 650 багшийг зөөврийн компьютерээр бүрэн хангасан.<br>3."Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024" арга хэмжээний хүрээнд орон сууцны дэмжлэгт багш гэр бүл болох дүүргийн 50 дугаар сургуулийн менежер А.Болдмаа, 39 дүгээр сургуулийн багш Н.Ган-Очир нар болзлыг хангаан шалгарч, батламжаа авсан. Элсэлтийн ерөнхий шалгалт болон олон улсын шалгалтад 800 оноо авсан 20 сурагчдад 1 сая төгрөг, бэлтгэн оролцуулсан 17 багшид тус бүр 2 сая төгрөгийн мөнгөн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урамшууллыг олгосон. Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 10 сурагч Хятад хэл, соёлыг амжилттай суралцаж БНХАУ-ын Элчин сайдын нэрэмжит тэтгэлэг, батламжийг гардан авсан.<br>4.2024 оны Элсэлтийн Ерөнхий шалгалтаар 800 оноо авсан 20 сурагчдыг бэлдэж сургасан 17 багшийг орон нутгийн сангаас шагнаж урамшуулсан.<br>5.Олон Улсын 2 хөтөлбөрийг 31 цэцэрлэг нэмэлтээр авч 10 багш БНСУ-д туршлага судалсан.<br>6.2024 оны 10 дугаар сард цэцэрлэгийн арга зүйчдийг Япон Улсад туршлага судласан. | |
| 13 | 2.3.2.3.Төгсөх ангийн сурагчдын сурлагын амжилтыг ахиулах зорилгоор амжилтын гараа уралдааныг зохион байгуулах | Тоо | Нийслэлийн Боловсролын газар | Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд нийт хүүхдийн 18 хувь нь хамрагдсан байна.Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноо 505 байна. | Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд нийт хүүхдийн 30 хувь хамрагдсан байна. Элсэлтийн ерөний шалгалтын дундаж / хэмжээст | Төгсөх ангийн сурагчдын сурлагын амжилтыг ахиулах зорилгоор "Амжилтын гараа-2024" уралдааныг 2024 оны 04 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн. Боловсролын үнэлгээний төвөөс Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын 12 дугаар ангийг 2023-2024 оны хичээлийн жилд төгсөж байгаа сурагчдад зориулж элсэлтийн ерөнхий шалгалтыг хэрхэн өгөх зөвлөгөө, зөвлөмж, мэдээлэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | /оноог 520-т хүргэнэ. | сургалтыг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 03 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд төрийн өмчийн 16 сургуульд зохион байгуулж, нийт 830 хүүхдийг хамруулсан. 3. Ерөнхий боловсролын сургууль төгсөх 12 дугаар ангийн сурагчдын элсэлтийн шалгалтын бэлтгэлд зориулж, "Шинэ алхам" гарын авлага, ном, цахим зөвлөмжийг нийт 16 сургуулийн 1482 сурагчид гардуулан өгсөн. | |
| 14 | 2.3.3.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт их засвар, дулаан техникийн шинэчлэлийн төслийг хэрэгжүүлж сургалтын орчин сайжруулна. | Тоо | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Нийслэлийн Боловсролын газар | 2020 онд 69 байгууллагыг их засвар, дулаан техникийн шинэчлэлийн төсөлд хамруулсан. | 85 байгууллагыг их, засвар, дулаан техникийн шинэчлэлийн төсөлд хамруулсан байна. | 139-р сургууль 1000000 төгрөгийн төсвөөр цахилгаан халаалтын тень солих, хэрэглээний цэвэр усны насос шинэчлэх, парыг угаах, зэв арилгах, хаалт солигдсон. 18-р цэцэрлэг 2633500 төгрөгийн төсвөөр гадна хашаа будах, биеийн тамирын заал, коридор, зайлшгүй засах шаардлагатай анги танхимын цууралтыг засах ажил бүрэн хийгдэж дууссан. 33-р цэцэрлэг 4000000 төгрөгийн Бүлгийн агааржуулалтын сэнс болон угаалтуурыг сольсон. Гадна талын талбайн засвар болон цэцэрлэгийн ус зайлуулах хоолойг засаж янзлах, будах, тоног төхөөрөмжийг засаж янзлах | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлууд хийгдэж дууссан. 39-р цэцэрлэг 5000000 төгрөгөөр сантехникийн зарим шугам сүлжээг засварлан ангиудын почкины ус алдалтыг зогсоож, крантуудыг шинэчлэн дуусаж байна. 83-р цэцэрлэг 7000000 төгрөгийн анги танхим нийтийн эзэмшлийн талбайд урсгал засвар бүрэн хийгдэж дууссан. 126-р цэцэрлэг 1070000 төгрөгийн Цахилгаан халаалтын тень солих, 2 байрны паарнуудыг авч зэв арилгах угаах, парны хаалт сольсон. 221-р цэцэрлэг 5000000 төгрөгийн анги бүлгийн аваарын хаалганд давхар хаалт хийсэн. 245-р цэцэрлэг 2200000 төгрөгийн цахилгааны халаалтын тогооны тень солих , хэрэглээний халуун усны насос засварлах ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. 275-р цэцэрлэг 4000000 төгрөгийн барилгын дээврийн хэсэгчилсэн засвар, гал тогоо болон агуулахын өрөөний засвар бүрэн хийгдэж дууссан. 138-р цэцэрлэг 3400000 төгрөгийн гүний худгийн цэвэр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | усны насос солих, спорт заалны засвар бүрэн хийгдсэн. 72-р сургууль 38000000 төгрөгийн сангийн шугам хэсэгчлэн солих, хөдөлмөрийн анги засварлах цонх хаалга, хана солих ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 15 | 2.3.3.2.Сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ | Тоо | Нийслэлийн Боловсролын газар | Гадаадын буцалтгүй тусламжийн хүрээнд 15 байгууллагад мэдээлэл зүйн лаборатори байгуулсан. | 80 байгууллагыг сургалтын хэрэглэгдэхүүн , тоног төхөөрөмжөөр хангасан байна. | Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн Ерөнхий боловсролын 20 сургуулийн багш нарт 925 ширхэг зөөврийн компьютер, сургуулийн өмнөх боловсролын 39 байгууллагын 130 багшид зөөврийн компьютер тус тус олгосон. Мөн цэцэрлэгийн Олон улсын 3 хөтөлбөрийн хүрээнд 31 цэцэрлэгт Стийм болон Айм Брийк тоглоомууд иж бүрэн олгосон. НҮБ-ын Хүүхдийн сангаас 57 дугаар сургууль дээр иж бүрэн төхөөрөмжтэй жишиг цахим танхим тохижуулж өгсөн. | 100 |
| 16 | 2.3.4.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалт зохион байгуулна. | Тоо | Нийслэлийн Боловсролын газар | Жилд 3 удаагийн сургалт зохион байгуулж байна. | Багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдттэй ажиллах ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг улиралд 1 удаа | 1.Дауны хам шинжтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч, багш нарт “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр даунтай хүүхдийг хөгжүүлэх нь” сургалтыг Монголын дауны холбоо, Нийслэлийн боловсролын газартай хамтран зохион байгуулсан ба сургалтад даунтай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан байна. | хүүхэд суралцдаг 2 багш хамрагдсан.<br>2."Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл" хэрэгжсэн зорилтот цэцэрлэг, сургуулиас 2 багш, төсөл хэрэгжээгүй 2 цэцэрлэг, сургуулиас тус бүр 1 нийт 16 багш танхимын сургалтад хамрагдсан.<br>3.Дүүргийн Ерөнхий боловсролын 20 сургуулийн 11, 38 цэцэрлэгт 28 хүүхэд хөгжүүлэх танхим байгуулан үйл ажиллагаа явуулж байна.<br>4.Дүүргийн Ерөнхий боловсролын 37 дугаар сургууль нь “Тэгш хамран сургах боловсрол” төсөлд хамрагдаж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлын туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран дүүргийн хэмжээний 17 сургууль, 39 цэцэрлэгийн нийт 168 багшид зохион байгуулсан ба уг арга хэмжээний хүрээнд эцэг эх, олон нийтэд мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчдад хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор дүүргийн 83 дугаар цэцэрлэгийн арга зүйч, багш нарт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сургалт зохион байгуулсан. Уг сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Хөгжлийн үнэлгээний мэргэжилтэн Г.Дэлгэртуяа “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх арга зүй”, Танин мэдэхүй хөтөлбөрийн багш Б.Сарантуяа “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг засан сайжруулах нь”, Хүүхдийн сэтгэл зүйч Г.Нямпагма “Хүүхдийн сөрөг зан төлөвийг бууруулах нь”, Хөгжим засал хөтөлбөрийн багш Г.Нарангэрэл “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжмөөр дамжуулан хөгжүүлэх нь” сэдвээр сургалт хийн өөрсдийн туршлагаа хуваалцсан. ХҮҮХЭД БҮХЭН ЖАРГАЛТАЙ БАЙГ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон эцэг эх асран хамгаалагчдад чиглэсэн зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөгийг “PDC MONGOLIA хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн Чингэлтэй салбар”, "Гэгээлэн" төвтэй хамтран зохион байгуулсан бөгөөд арга хэмжээнд 120 хүүхэд хамрагдсан. НҮБ-ын Хүүхдийн сангаас 57 дугаар сургууль иж бүрэн төхөөрөмжтэй жишиг цахим танхим тохижуулсан. “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн "Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах" арга зүйн зөвлөгөө өгөх уулзалтыг БЕГ Японы Токио хотын Гакугэй их сургуулийн профессор Хашимото багштай хамтран зохион байгуулсан ба сургалтад дүүргийн 38 цэцэрлэгийн 72, 18 сургуулийн 28 багш хамрагдсан. “Дауны хам шинж” оноштой 6 настай хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс ирүүлсэн цэцэрлэгт үргэлжлүүлэн 1 жил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулах хүсэлтийн дагуу сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтыг үндэслэн тухайн цэцэрлэгт үргэлжлүүлэн хамруулсан. | |
| 17 | 2.3.5.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлнэ. | Хувь | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Нийслэлийн Боловсролын газар | - | Нийт сургуулийн 100 хувийг хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоонд шилжүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд түрээсийн гэрээг цуцалж бие даан хүүхдийн хоол үйлдвэрлэлээ явуулж байгаа 11 сургууль нь *mender.mn* цахим дэлгүүрээс мах, сүү, нарийн ногоо, “Багачууд хүнс” ОНӨААТҮГ-аас хуурай хүнс, мах, жимс, “Талх чихэр” ХХК-иас боорцог, печень, “АПУ” ХК, “Сүү” ХК-иудаас сүү, цөцгий худалдан авч хүүхдийг шим тэжээллэг хүнсээр хангаж байна. | 70 |
| 18 | 2.3.5.2.Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд цахим захиалгын систем нэвтрүүлнэ. | Хувь | | - | - | Хоол үйлдвэрлэл үйлчилгээний "Арта” цахим системийг нэвтрүүлэх сургалтад дүүргийн нийт цэцэрлэгийн эрхлэгч нар бүрэн хамрагдсан бөгөөд цахим системийг худалдан авахаар 72, 139 дүгээр сургууль захиалгын гэрээ байгуулаад байна. | 70 |
| 19 | 2.3.6.1.Ерөнхий боловсролын сургууль, | Хувь | Нийслэлийн Засаг даргын | Нийт сургууль, цэцэрлэгийн 70 | Бүх сургууль, цэцэрлэгийн | Дүүргийн хэмжээнд төрийн болон төрийн бус Ерөнхий | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийг цахимаар зохион байгуулна. | | Тамгын газар Нийслэлийн Мэдээлэл технологийн газар Нийслэлийн Боловсролын газар | хувь цахим системээр элсэлт бүртгэлийн үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. | элсэлтийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулдаг болсон байна. | боловсролын 27 сургууль, 47 цэцэрлэгийн цахим системээр элсэлтийн бүртгэлийн ажлыг зохион байгуулсан. 2024-2025 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 2565 хүүхэд, цэцэрлэгийн 1 дүгээр шатны элсэлтийн цахим бүртгэлд хүсэлт гаргасан 7583, 2 дугаар шатны элсэлтээр хүсэлт гаргасан 531, нийт 8114 суралцагчийг хамран сургах тойргийн цэцэрлэгт хуваарьласан. Төрийн бус өмчийн 9 цэцэрлэгт 614 суралцагч элсэн суралцаж байна. | |
| 20 | 2.3.6.2.Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээнд цахим хичээлийн иж бүрэн сан, даалгаврын сан бүрдүүлэн интернэтэд байршуулж, сурагчид үнэ төлбөргүй үзэх замаар бие даан суралцах боломжийг нэмэгдүүлнэ. | Тоо | | – | Е-контентийн тоог 800, цахим даалгаврын санг 12,000-д хүргэсэн байна. | Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээнд цахим хичээлийн иж бүрэн санд 1654, даалгаврын санд 1325 материалыг бүрдүүлэн, сурагчид үнэ төлбөргүй үзэж, мэдлэгээ сорих *soril.eec.mn, suraad.mn, marchaahai.mn medle.mn* цахим сайтад хандаж бие даан судлах, суралцах боломжийг нэмэгдүүлсэн. Мөн *medle.mn* сайтад 8 багшийн 6 нэгжийн 47 хичээл, даалгаврын санд 24 цахим хичээлийн иж бүрэн баяжилтыг тус тус хийсэн. Дүүргийн Ерөнхий боловсролын 117 дугаар сургууль Eduten | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд цахим орчинд ажиллах танхим, 57 дугаар сургууль иж бүрэн техник хэрэгсэлтэй цахим танхимыг тус тус нээж сурагчдын сурах таатай орчныг бүрдүүлсэн. | |
| **НИЙГМИЙН ХАЛАМЖ** | | | | | | | |
| **2.4.Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 21 | 2.4.1.1.Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг амьдралын зөв дадал хэвшилд сургах, түр хоноглох үйлчилгээнд хамруулна. | Тоо | Нийслэлийн Нийгмийн халамжийн газар | Түр хоноглох үйлчилгээнд 300 хүнийг хамруулсан | Түр хоноглох үйлчилгээнд 300 хүнийг хамруулна. | Дүүргийн хэмжээнд гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг бичиг баримтжуулах үйлчилгээг үзүүлсэн “Тэрэм-уул” ХХК-ний үйлчилгээнд 2024 онд 39 иргэн хамрагдаж 49185000 төгрөгийг зарцуулсан. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг Монголын сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран сүрьеэгийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Түр хоноглох байр, бичиг баримтжуулах зэрэг үйлчилгээ үзүүлж буй “Тэрэм-уул” ХХК үйлчилгээ авч буй иргэдийн бүртгэл, судалгааг шинэчлэн нягтлаж шинээр ирсэн 2 иргэнийг цахим бүртгэлд бүртгэж, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, “Тэрэм-Уул” ХХК-тай хамтран гэр авч өгсөн. | 100 |
| 22 | 2.4.1.2.Зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн | Тоо | Нийслэлийн Нийгмийн | Нийгмийн хамгааллын | Нийгмийн хамгааллын | Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.9 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, хамт олны бүлэг бүрдүүлэн орлогын эх үүсвэртэй болох нөхцөлийг бүрдүүлнэ. | | халамжийн газар | суурь үйлчилгээнд зорилтот бүлгийн 485 хүн хамруулсан. | суурь үйлчилгээнд 500 хүн хамруулна. | дэх заалт, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын баталсан “Бүлгийн төсөл хэрэгжүүлэх” удирдамжийг үндэслэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөл хүлээн авах ажлыг зохион байгуулан 18 төслийн 36 иргэнд 54000000 сая төгрөгийн санхүүжилт олгон ажилласан байна. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээний хүрээнд эрх бүхий 7 сургалтын байгууллагатай гэрээ байгуулсан. Ганцаарчилсан зөвлөгөөнд 900 иргэн, бүлгийн сургалтад 1100 иргэн, нийт 2000 иргэнд хөдөлмөр эрхлэлт, мэргэжил сонголтын талаар зөвлөгөө мэдээлэл, сургалтыг зохион байгуулсан. “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих” үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 79 төсөл хүлээн авснаас 56 төслийг шалгаруулж 450 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Арга хэмжээний үр дүнд 56 иргэн байнгын ажлын байртай болсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | 2.4.2.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Тоо | Нийслэлийн Нийгмийн халамжийн газар | Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй 350 хүнийг хамруулсан. | Нийгмийн хамгааллын үйлчилгээд хөгжлийн бэрхшээлтэй 800 хүнийг хамруулна. | Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 1354 иргэнд 629,567,983.0 төгрөгийн хөнгөлөлт, тусламж олгосон. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих” үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 50 төсөл хүлээн авч, 31 иргэний төслийг сонгон шалгаруулж 206 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Арга хэмжээний үр дүнд 20 иргэн байнгын ажлын байртай болсон. Хөгжлийн бэрхшээлтэй, төсөл хэрэгжүүлэгч иргэдэд аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох зээлийн өмнөх болон дараах сургалтыг “Мэргэшсэн мэргэжил” сургалтын төвтэй хамтран зохион байгуулж зорилтот бүлгийн 133 иргэн хамрагдсан. “Итгэлт бүтээмж” сургалтын байгууллагатай хамтран бэлэг дурсгал, гар урлалын чиглэлээр мэргэжил олгох сургалтад 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан. | 100 |
| **Хөдөлмөр эрхлэлт** | | | | | | | |
| **2.5. Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.** | | | | | | | |
| 24 | 2.5.1.1.Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга | Тоо | - | Гарааны бизнес эрхлэлтийн | 80 залуучуудын | Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ. | | | дэмжлэг 78 залуучуудын бүлэг авсан. | бүлэгт дэмжлэг үзүүлсэн байна. | тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/39 тушаалын дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд 2024 оны 04 дүгээр сарын 12-ноос 05 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл зарлан нийт 170 иргэн төсөл ирүүлсэн. 2024 онд хэрэгжих хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг олгох төслийг зарлан 24 хорооны иргэний танхимын цахим хуудас, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ мэдээллийг түгээж ажилласан. Ажлын хэсэг төслийн сонгон шалгаруулалтыг хийж, ажлын байрны хяналт дээр ажиллаж байна. Шилдэг стартап гарааны бизнес болон залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох "Стартап-2024" Улсын уралдаан 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл үргэлжилж нийт 198 залуучууд бүртгүүлж, 1 дүгээр шатанд 40 баг шалгарч сургалтад хамрагдаж, шилдэг стартапаар шалгарсан нэг баг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүжилт авсан. Сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалга 1000, ажил идэвхтэй хайж буй 955 иргэнийг бүртгэж, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 756 иргэнийг тохирч тэнцэх ажлын байранд нь зуучилсан. | |
| 25 | 2.5.1.2 Оюутан залуучуудыг цагаар ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэн, суралцах хугацаанд нь хөдөлмөр эхлэлтийн түүхтэй болгоно. | Тоо | Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар | Цагийн ажилд 6,799 оюутан хамрагдсан. | 7,000 оюутан залуучуудыг цагийн ажилд хамруулсан байна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, "Грийн групп" ХХК-тай хамтран 2024 оны 1 дүгээр ээлжийн цэргийн албанд татагдан цэргийн алба нэр төртэй хаагаад ирж буй 100 гаруй залууст ажил мэргэжлийн зөвлөгөө, сул чөлөөтэй ажлын байрны танилцуулга мэдээллийг өгч, 50 иргэнийг холбон зуучилсан. | 70 |
| 26 | 2.5.2.1.Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн систем болон цахим хөдөлмөрийн биржийг хөгжүүлэх замаар үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Тоо | Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар | 1,500 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. | 2,500 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2017 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 3.4.7, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын даргын 2017 оны А/161 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаанд тавигдах шалгуур | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүлэлтийг тогтоох аргачлал батлах тухай” тушаалын дагуу стандартын шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргуулахаар хүсэлт гаргасан “Итгэлт бүтээмж төв” ТББ-ын дэргэдэх Хөдөлмөрийн бирж, “Вест метод” ХХК-ний дэргэдэх Хөдөлмөрийн биржийн суурь баримт бичгийг боловсруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газарт хүргүүлсэн. Шинээр бий болсон 550 ажлын байрыг бүртгэн хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем “И жоб” программд оруулсан. | |
| 27 | 2.5.2.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон цагийн болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ. | Тоо | Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон түр болон цагийн 320 ажлын байр | 100 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан байна. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар 37 иргэн төслөө ирүүлсэн бөгөөд ажлын хэсгийн сонгон шалгаруулалт явагдаж, 206 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 15 иргэнийг түр ажлын байраар, 20 иргэнийг байнгын ажлын байраар хангасан. | 70 |
| | | | | | | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур, уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэр, барилга, техник, худалдаа үйлчилгээ, бөөний болон жижиглэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 2.5.2.3. Мэргэжилийн болон давтан сургалтад иргэдийг хамруулан тохирох ажлын байранд зуучилна. | Тоо | Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар | Мэргэжлийн болон давтан сургалтад 1,056 хүн хамрагдсан. | 550 иргэнийг сургалтад хамруулж мэргэшүүлсэн байна. | худалдаа, ахуйн засвар үйлчилгээний чиглэлээр суралцах хүсэлтэй 128 иргэний судалгааг нэгтгэн нийслэлийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлсэн. Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд 38 иргэн сургалтад бүртгүүлсэн бөгөөд суурь ур чадварын сургалтад 253 иргэн хамрагдсан. | 70 |
| 29 | 2.5.2.5.Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах өдөрлөгийг тогтмол зохион байгуулна. | Тоо | Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар | 1 өдөрлөг зохион байгуулсан. | Жилд 1 удаа зохион байгуулсан байна. | "Хөдөлмөр эрхлэлт-2024" нэгдсэн өдөрлөгт дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар 300 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Ажил олгогчийн төлөөлөл “Чиглэл” ХХК, “Бишрэлт групп” ХХК, “Сүлд” ХХК оролцож, нээлттэй 685 ажлын байрны танилцуулга мэдээллийг хүргэн, гадаадад ажиллаж байгаад ирсэн иргэдэд төсөл хөтөлбөрийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөн ажилласан. | 100 |
| | | | | | | 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | 2.5.2.6. Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудад зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна. | Тоо | Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар | Нөлөөллийн арга хэмжээнүүд зохион байгуулагдсан. | Жилд 1 аян зохион байгуулсан байна. | зөвлөл хуралдаж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулах 10 ажил бүхий төлөвлөгөө, 2024 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус батласан. Төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдэд аюулгүй орчинд хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндээ хамгаалах талаарх сургалтыг 1 удаа, аж ахуйн нэгж, байгууллагад ХАБЭА, ҮОМШӨ талаарх нөлөөллийн ажил, сургалтыг 5 удаа тус тус зохион байгуулсан. Монголын Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд зохион байгуулагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2024” арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд 10 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл 12 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ХАБЭА, ҮОМШӨ талаарх нөлөөллийн ажил, сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв” ОНӨТҮГ болон дүүргийн 1 дүгээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хорооны Засаг даргын ажлын албатай хамтран жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 82, ХАБЭА-н инженер техникийн 20 ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер, техникийн ажилтнуудад зориулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад 15 аж ахуйн нэгж, байгууллагын 20 төлөөлөл, дүүргийн Цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн алба хаагчдад "Ажлын байрны аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх" сэдэвт сургалтыг зохион байгуулж, хэлтсийн 78 ажилтан, албан хаагч тус тус хамрагдсан. | |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр** | | | | | | | |
| **3.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангана.** | | | | | | | |
| 31 | 3.3.1.4. Нийслэлийн хүн амын хаврын махны хангамж, үнийг тогтвортой хадгалах зорилгоор мах бэлтгэн нөөцлөх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулна. | Тоо | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | 12,000 тонн нөөцийн махыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан. | 18,000 тонн нөөцийн махыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулна. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны А/344 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай”, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1147 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны “Хүн амын стратегийн хүнсний нөөцийг тогтвортой, тэнцвэртэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байлгах зорилтын хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” А/233 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс нөөцийн мах худалдан борлуулагдаж эхлэхтэй холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн мах худалдан борлуулах бэлтгэл ажиллагааг хангах, тавигдах шаардлагын хэрэгжилт, хөргөгч хөлдөөгчийн багтаамж, нөөцлөх боломжтой махны хэмжээ, эрүүл ахуй аюулгүй байдал стандартын шаардлага хангасан 35 аж ахуйн нэгж, байгууллага, “ХКҮ” ХХК, “Булган мах маркет” ХХК зэрэг бэлтгэн нийлүүлэгч 2 компанитай “Бэлтгэн нийлүүлэгч, агентын гэрээ” байгуулсан. Нөөцийн мах жижиглэнгээр худалдан борлуулсан дүүргийн 35 хүнсний дэлгүүр нь үхрийн мах 25147 кг, хонины мах 18274 кг, нийт 43421 кг мах худалдан борлуулсан.<br>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан "Хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд нөөцийн махны өргөтгөсөн худалдааг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүүргийн 4 байршилд долоо хоног бүрийн мягмар, пүрэв, бямба, ням гарагуудад зохион байгуулж хонины мах 346152 кг, үхрийн мах 71370 кг, ямааны мах 11967 кг, нийт 429489 кг махыг тус тус худалдан борлуулсан байна. | |
| 32 | 3.3.3.2."Алтан намар" арга хэмжээний хүрээнд эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг зохион байгуулна. | Тоо | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Өргөтгөсөн худалдаанд 1,000 тонн төмс, хүнсний ногоо борлуулсан. | Өргөтгөсөн худалдаагаар худалдаалагдсан төмс, хүнсний ногоог 1,100 тоннд хүргэсэн байна. | Нийслэл Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны “Төмс хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай” А/133 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Алтан намар-2024” арга хэмжээг дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачдын талбайд 23, 2 дугаар хороо, Бөмбөгөр худалдааны төвийн гадна талбайд 10, 24 дүгээр хороо, жигжидийн уулзварт 2, нийт 3 байршилд 35 хүнсний ногоо тариалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэлх хугацаанд төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг зохион байгуулан ажилласан. Хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гарал үүслийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичиг, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийг үндэслэн төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаанд хамруулан ажилласан. Тус өргөтгөсөн худалдаа болсон 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 09 дүгээр сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд 23 нэр төрлийн 77.5 тонн төмс, хүнсний ногоог 300.722.500 төгрөгөөр борлуулж ажилласан. | |
| 33 | 3.3.3.5. Стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудыг тохирлын гэрчилгээгээр баталгаажуулна. | Тоо | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Тохирлын гэрчилгээтэй хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар хотын хэмжээнд 70 байна. | Тохирлын гэрчилгээтэй хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг хотын хэмжээнд 180-д хүргэсэн байна. | Монгол Улсын Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд нь тухайн үйлчилгээний ангилал, стандартад тавигдах шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах, эрх бүхий байгууллагаар ангиллаа тогтоолгох үүрэг хүлээсэн байдаг бөгөөд тус чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад авто үйлчилгээний ангиллын хугацаа дууссан болон ангилал тогтоолгоогүй авто үйлчилгээ эрхлэгч 36 иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад мэдэгдэл, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмж өгч ажилласан. 2024 онд авто үйлчилгээний 9, хоол үйлдвэрлэлийн 11, худалдааны 49, нийт 69 аж ахуйн нэгж, байгууллага тохирлын гэрчилгээнд хамрагдсан байна. | |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилго 4.1 Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно.** | | | | | | | |
| 34 | 4.1.4.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн нээлттэй санал асуулгыг цахимаар буюу ухаалаг гар утасны аппликейшн ашиглан зохион байгуулна. | Хувь | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 9 дүүрэгт зохион байгуулагдаж, санал өгөх боломжтой нийт 806 мянган иргэдийн 43.1 хувь нь санал өгсөн. | 9 дүүрэгт зохион байгуулж, санал өгсөн иргэдийн 70 хувьд хүргэсэн байна. | - Дүүргийн Засаг даргын 2023 оны “Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах ажлыг зохион байгуулах тухай” А/130 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нарт захирамжийг хүргүүлсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал асуулгыг дүүргийн 1-24 дүгээр хороодод зохион байгуулж өдөр бүр саналын явцын тайланг авч, *“Чингэлтэй дүүрэг/Chingeltei District”* цахим хуудас болон хороодын цахим хаягаар иргэд олон нийтийг мэдээ, мэдээллээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангаан ажилласан. Мөн гар утасны аппликейшн ашиглаж чадахгүй өндөр настан болон эмзэг бүлгийн иргэдээс цаасаар санал авахаар төлөвлөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/140 дүгээр тушаалаар нийт 22000 саналын хуудас хэвлүүлэн хороодод тарааж цаасаар санал аван ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх төсөл, арга хэмжээнд дүүргийн 1-24 дүгээр хороодын иргэд цахимаар 4491, цаасаар 96974, нийт 101465 санал өгсөн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад иргэдээс ирүүлсэн саналын дагуу ажлын хэсэг газар дээр нь ажиллаж жагсаалтыг боловсруулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан. | |
| **ТАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилго 5.1 Байгалийн нөөц баялаг, экосистемийн үнэ цэнийг хадгалж, хамгаалах, нөхөн сэргээх, усны нөөц, урсац бүрэлдэх эхийг хамгаалалтад авч, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 35 | 5.1.1.1.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан | Тоо | Улаанбаатар хотын | 18 цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан | 1 цэцэрлэгт хүрээлэнг | Дүүргийн хэмжээнд одоогийн байдлаар 84 бичил цэцэрлэг байгаа бөгөөд арчилгаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэцэрлэгт хүрээлэн байгуулж, олон нийтийн амралт зугаалгын талбай байгуулна. | | Захирагчийн ажлын алба | | байгуулсан байна. | хамгаалалтыг дүүргийн “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн ажиллаж байна. Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын хүрээнд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 тоглоомын талбай, дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр сэргээн засаж сайжруулсан 2 бичил цэцэрлэг хүрээлэн, нийт 5 тоглоомын талбай, бичил цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан. Дүүргийн 19 дүгээр хороо, Тахилтын амны цэцэрлэгт хүрээлэнгийн явган замын ажил, 24 дүгээр хороо, Зуун модны зуслангийн тохижилтын ажил тус тус хийгдэж дууссан. | |
| 36 | 5.1.1.3.Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулна. | м2 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 4.8м2 | Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 0.64м-аар нэмэгдүүлсэн байна. | “Тэрбум мод” аяны хүрээнд тус дүүргийн 19 дүгээр хороо, “Хайрхан хөгжил-1” төв болон 16 дугаар хороо, “Хоймор хайрхан” ахмадын амралтын газар, 84 бичил цэцэрлэгүүд, 1-24 дүгээр хороодын авто зам, байшин хорооллын дундах нийтийн эзэмшлийн талбайд 61550 шилмүүст мод, навчит бут мод 58269, нийт 119819 мод бут тарисан. Мөн 2024 оны үйл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааны хүрээнд дүүргийн ногоон байгууламжийн хэмжээг 28000м2-аар нэмэгдүүлж арчлалт, хамгаалалтыг "Чингэлтэй тохижилт үйлчилгээ" ХХК, "Ногоон төгөл" ХХК, "Масон энержи" ХХК-иуд хариуцан тухай бүр зөрчил дутагдлыг арилган ажиллаж байна. Мөн дүүргийн нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 0.64м-аар нэмэгдэж 5.44м болсон. | |
| 37 | 5.1.1.4.Хотын ногоон байгууламжийн эрх зүйн орчин, санхүүжилтийн эх үүсвэрийг сайжруулна. | м2 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | - | Өөрсдийн хөрөнгөөр гадна талбайн ногоон байгууламжаа нэмэгдүүлсэн аж ахуйн нэгж байгууллага нэмэгдсэн байна. | Өөрийн хөрөнгөөр тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих зорилгоор “Манай хороо-Миний гудамж” аяны хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийг шагнаж урамшуулахаар төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. 1-24 дүгээр хороодын аж ахуйн нэгж, байгууллагуудаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн явж тохижилтын ажлыг эрчимжүүлэхээр шаардлага хүргүүлэн ажилласан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас өгсөн *"like.unlike"* стикер ашиглан байгууллагуудын үүдэнд байршуулан ажилласан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 38 | 5.1.1.5.Гэр хорооллын айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжиж ажиллана. | Тоо | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | - | Хашаандаа ногоон байгууламж, мод тарьсан айл өрхийн тоо нэмэгдсэн байна. | 2024 оны хаврын тарилтын хүрээнд дүүргийн 19 дүгээр хорооны “Хайрхан хөгжлийн төв” ОНӨТҮГ-т дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад, 1-24 дүгээр хороодын нийт 600 албан хаагч 300 шилмүүст нарс, шинэс, 200 улиас, 3500 хайлаас, тариад байна. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудаас Геодези, усны барилга байгууламжийн газар 50 улиас тариалаад байна. Мөн Нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар нь “Хайрхан хөгжил төв” ОНӨТҮГ-тай цэнэг усалгаанд хамтран ажилласан бөгөөд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар нь 50 гацуур тус тус тариалаад байна.<br>“Ногоон хот-иргэний оролцоо өрх бүр хашаандаа мод тарья” сургалт хэлэлцүүлгийн хүрээнд дүүргийн 7-24 дүгээр хороодын айл өрхийн төлөөллийг сургалтад хамруулсан. “Хашаандаа мод тарья” аяны хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Чингэлтэй дүүрэгт хуваарилсан 2700 ширхэг мод бут сөөгийг мод тарих | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүсэлтэй иргэдэд тараан арчлалт хамгаалалтын заавар зөвлөгөө өгч ажилласан. | |
| 39 | 5.1.1.6.“Шарилжгүй Улаанбаатар” аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | м2 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | 4.8 сая м2 | 4 сая м2 талбайд шарилж зэрлэг ургамлыг устгасан байна. | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас уламжлал болгон зарладаг “Шарилжгүй Улаанбаатар” аяныг нийслэлийн хэмжээнд хоёр үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.<br>Дүүргийн хэмжээнд 2024 оны 06, 08 дугаар саруудад хоёр үе шаттайгаар хөл газрын ургамлын тоосноос үүдэх харшлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн тоог бууруулах, хөл газрын ургамлыг тайрах, хадах, зэрэг ажлыг нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, далан суваг, гуу ж алга дагуух шарилж луулийг цэвэрлэн ажиллалаа.<br>Дээрх цэвэрлэгээний ажилд дүүргийн 1-24 дүгээр хороодын ажлын алба, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, тээвэрлэгч байгууллагууд оролцож нийт давхардсан тоогоор 3118 гаруй хүн цэвэрлэгээний ажилд хамрагдан 721328 м2 талбайг цэвэрлэн, нийт 197 рейсээр 506.5 тонн шарилж луулийг 3 техник хэрэгслээр тээвэрлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс хороо тус бүрд 10 хүний бүрэлдэхүүнтэй буюу 240 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллаж байна. Дүүргийн 1-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт хөл газрын ургамлын тоосноос үүдэх харшлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн тоог бууруулах, хөл газрын ургамлыг тайрах, хадах, шаардлагатай зориулалтын төхөөрөмжийг хороо тус бүрд буюу гэр хорооллын 7-24 дүгээр хороонд 2 ширхэг, төвийн бүс буюу 1-6 дугаар хороонд 1 ширхэг, нийт 42 ширхэг зориулалтын төхөөрөмж дүүргээс олгон ажилласан. | |
| 40 | 5.1.2.1.Иргэд, олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна. | Тоо | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг 23 | Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг 9-өөр нэмэгдүүлсэн байна. | Дүүргийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 84 бичил цэцэрлэгт хүрээлэн, сагсан бөмбөгийн талбай, 1-24 дүгээр хороодод 136 у/км явган замын арчлал хамгаалалт, бичил цэцэрлэгийн засвар үйлчилгээг дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр дүүргийн “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК хийж гүйцэтгэн ажиллаж байна. Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын хүрээнд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 3 тоглоомын талбай, дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр сэргээн засаж сайжруулсан 2 бичил цэцэрлэгт хүрээлэн, нийт 5 тоглоомын талбай байгуулсан. Гэр хорооллын болон орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн явган зам барих чиглэлийн дагуу 3000 м2 хөтөчтэй явган зам байгуулахаар судалгааг гаргаж нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн бөгөөд 2 компани шалгаран 23, 24 дүгээр хороодод байгуулсан. Дүүргийн хэмжээнд орчны аюулгүй байдал хангах нийт ажлын хүрээнд 1, 3-6, 11, 12, 15-17, 23 дугаар хороодод нийт 3500 м2 явган зам, 750 м2 байгалийн чулуун зам, 4750 м2 асфальтан хучилтын ажил, 11 байршилд газар чөлөөлөлтийн ажил хийгдсэн. | |
| | | | | | | Гэр хорооллын болон орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн тохижилтын ажил хийх чиглэлийн дагуу Улс, нийслэлийн төсвийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | 5.1.2.4.Тохижилтын ажлын үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, бичил тохижилт бүхий амралт, спортын талбайг сэргээн засварлах ажлыг зохион байгуулна. | Тоо | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | - | Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн засварласан байна. | хөрөнгөөр 6 бичил цэцэрлэгийн засварын ажлыг хийж гүйцэтгэхээр тендер сонгон шалгаруулалтыг зарлан компаниуд шалгарч ажлыг эхлүүлээд байна. Хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор хүүхдийн тоглоомын талбайн стандартын хэрэгжилтийг хангах засварын ажлын хүрээнд 84 бичил цэцэрлэгээс 15 тоглоомын талбайд хүүхдэд аюултай хашаа хайс засварлах, эвдрэлтэй тоглоомыг солих, гагнуурын ажлууд хийгдсэн. "Зуршлаас хэвшил рүү" аяны хүрээнд хөдөлгөөнт амьдралыг хэвшил болгохоор зорилт тавин "Бичил глобус" санхүүгийн байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд 9 байршилд "Унадаг дугуйн зогсоол" байршуулсан ба Ялалтын талбай, 5-р сургууль, Соёл Урлагийн Их сургууль, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Өглөөний гудамж, Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэн, Баянбүрд орчим, 24-р сургууль, Компьютер ланд төв зэрэг газарт тус тус байршууллаа. Шуурхай хурлаар | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өгсөн чиглэлийн дагуу дүүргийн менежерээр ахлуулсан Аян зохион байгуулах удирдамж гарган дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудын 50 метр хүртэлх талбайг засварлах, ногоон байгууламж бий болгох хог хаягдлыг цэвэрлүүлэх аяныг зарлан ажилласан. Тохижилт, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын хүрээнд дүүргийн 5 дугаар хороо, 2а байрны тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 6 дугаар хороо, 33 дугаар байрны авто зогсоол тоглоомын талбайн ажлыг хийж гүйцэтгэсэн. | |
| **Хөрс, орчны бохирдолгүй хот** | | | | | | | |
| 42 | 5.2.6.3.Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ. | Хувь | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | 3710 өрх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж ашиглаж байна. | 2000 өрхийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгосон байна. | Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Барилга, хот байгуулалтын яамнаас Улсын төсвийн хөрөнгөөр 2023-2024 онд он дамжин хэрэгжих 4.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлонг сайжруулах, айл өрхийн байшингийн дулаалга хийх” цогц | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлыг хэрэгжүүлээд байна. Үүнд: дүүргийн 7, 12-19 дүгээр хороодын нийт 150 айл өрх хамрагдан 2023 оны 08 дугаар сард бүрэн хэрэгжиж дуусан комисс хүлээн авсан. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 онд 1.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлонг сайжруулах” ажлын хүрээнд дүүргийн 7, 17-19 дүгээр хороодын нийт 400 айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэхээр нүхийг ухаж бэлтгэн кольц суурилуулж 58 айл өрх хамрагдаж дутуу орхигдсон бөгөөд 2023 оны 04 дүгээр улиралд багтаан бүхээг суурилуулах ажил хийгдэж дуусгахаар төлөвлөсөн боловч лагийн үйлдвэрийн ажил удааширсантай холбоотойгоор албан бичгийг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 2/2977 тоот албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Орчны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бохирдлыг бууруулах Үндэсний хороонд хүргүүлсэн. | |
| 43 | 5.2.7.3.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ. | Хувь | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Цахим систем байхгүй | Цахим системийн нэвтрүүлэлтийн хувь хэмжээ-100 хувь | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 22 дугаар тогтоолоор энгийн хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн батлуулж 2024 оны 04 дүгээр сарын 01-ноос буюу 02 дугаар улирлаас эхлэн дагаж мөрдөхөөр төлөвлөсөн боловч тодорхой шалтгааны улмаас хойшлогдон дээрх батлагдсан тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг өргөн барьж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 08 дугаар тогтоолоор батлагдан 2025 оны 01 дүгээр сараас эхлэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас үүсэх хог хаягдлын нэгж тарифыг дагаж мөрдөхөөр төлөвлөн ажиллаж байна.<br>Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг дүүргийн Татварын хэлтэс 2024 оны 01 дүгээр улирлаас эхлэн хэрэгжүүлж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлын төлбөр хураамжаа нэхэмжлэх үүсгэн онлайнаар төлж хэвшээд байна. | |
| **Үнэлгээний дундаж** | | | | | | | **92.7%** |

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР